



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 79

Номгон

Нөхөн сэргээлтийн талаар авах
арга хэмжээний тухай

Баянхонгор аймагт 2000-2003 оныг дамнасан ган, зудын аюул нүүрлэж 2.5 сая малтай байсан аймаг 0.7 сая малтай болон хорогдож, олон арван малчид маллах малгүй болж, амьжиргааны түвшин эрс доройтсоноос аргагүйн эрхэнд байгалийн баялаг болох алт хайж гар аргаар алт олборлох болсон. Мөн тухайн үед Монгол Улсын Засгийн газраас баталсан Алт үндэсний хөтөлбөр эрчимжиж эхэлснээр уул уурхайн салбар олборлолтод түлхүү анхаарч байгаль орчны нөхөн сэргээлтийг орхисноор ихээхэн хэмжээний газар эвдэгдэн холбогдох эзэнгүй болжээ.

Эдгээр газруудыг Улсын болон Орон нутгийн төсвөөс хөрөнгө гарган нөхөн сэргээх боломж хомс байгаагийн дээр хаягдал нөөцийг авалгүй нөхөн сэргээсэн тохиолдолд гар аргаар алт олборлогч иргэд тухайн газрыг дахин ухах асуудал гарч, хаягдал нөөцийг ашиглах замаар нөхөн сэргээлт хийх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаатай холбоотойгоор аймгийн хэмжээнд эвдэрсэн газрууд нэмэгдэх хандлагатай байна.

Эвдэрсэн газрын 2009 оны тооллогоор 12 сумын 208 цэгт гар аргаар болон уул уурхайн нөлөөгөөр 708 га газар эвдэгдсэн гэсэн дүн гарсан. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтөд өртөж, эмзэг байгаа цөлийн болон цөлөрхөг хээрийн ургамлан бүрхэвч, малын бэлчээр, биологийн төрөл зүйлийг устгаж, мал амьтан унаж осолдох олон тооны нүх үлдээж байна.

Энэ талаар иргэд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдлаас хамгаалуулах эрхтэй гэж заасны дагуу эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийлгэх хүсэлтээ тухайн багийнхаа Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд уламжилсан зэргийг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Газрын хэвлийн тухай хуулийн 7.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл

0117027

ажиллагааны хөтөлбөрийн 113 дугаар зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэн холбогдогч нь тогтоогдох боломжгүй болж орхигдсон, багийн Иргэдийн нийтийн хурлаар нөхөн сэргээх шаардлагатай гэж үзэж санал болгосон талбайд орон нутгийн татварын албанд бүртгэлтэй, нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй нөхөн сэргээлтийн гэрээ байгуулж хамтарч ажиллаж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

2. Эвдэрсэн болон одоо ашиглаж байгаа талбайдаа нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан ч тухайн газарт нөхөн сэргээлт хийгээгүй, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн компаниудын байгаль орчинд учруулсан хохирлыг тооцож хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Цаашид орон нутагтаа аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, иргэний ашигт малтмал эрж хайх, олборлох үйл ажиллагааг тухай бүр нь шуурхай ажиллан таслан зогсоож, буруутай этгээдээр учруулсан хохирлыг арилгуулж хяналт шалгалтыг өндөржүүлж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагын дарга, Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР